

ТАТВАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ БА ТАТВАРЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНД ХИЙСЭН СУДАЛГАА, ҮР ДҮН

Д.Моломжамц*, Б.Цэвээнсүрэн**, Л.Баасандорж***

Хураангуй: Монгол Улсын Татварын Албанаас “Big data” төслийг хэрэгжүүлсэн бөгөөд үүний үр дүнд татвар төлөлттэй холбоотой эрсдэлийн үнэлгээ, татварын скоринг гаргаж, татварын хяналт шалгалтад хамрагдах татвар төлөгчдийг оновчтой таамагладаг болж байна. Энэхүү өгүүллээр уг төслийн хэрэгжүүлэлтийн талаарх үндэсний болон олон улсын туршлага, татварын эрсдэл, скоринг хийх арга зүй, эрсдэлийн ерөнхий үнэлгээ, түүнийг бууруулах болон татварын скорингийг сайжруулах талаарх судалгааг тодорхой судалгаанд тулгарсан бодит жишээгээр тайлбарласан болно.

Түлхүүр үгс: татварын скоринг, татвар төлөгч, цахим тайлангийн систем, татварын тайлан, их өгөгдлийн бааз, татварын эрсдэлийн үнэлгээний оноо

RESEARCH AND RESULTS OF TAX CONTROL AND TAX RISK ASSESSMENT

Abstract: As a result of the implementation of the “Big data” project by the Mongolian Tax Administration, risk assessment, tax scoring, and tax control related to tax payment can be accurately predicted. This article shows the national and international experience of the implementation of the project, tax risk and scoring methodology, general assessment of risk, its reduction and improvement of tax scoring and we have explained this research with real examples.

Keywords: tax scoring, taxpayer, e-reporting system, tax reporting, big data base, tax risk assessment score

* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): molomjamts0112@yahoo.co.jp “

** “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮТ-ын дэргэдэх, ШУТИС-ийн харьяа Эрдэнэт цогцолбор дээд сургууль, (E-mail): tseveenmta@gmail.com

*** “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮТ-ын дэргэдэх, ШУТИС-ийн харьяа Эрдэнэт цогцолбор дээд сургууль, (E-mail): baasandorj@erdenetis.edu.mn

Удиртгал

Дэлхийн аль улс оронд татвар төлөх нь иргэний үндсэн үүрэг байдаг бөгөөд уг үүргийн биелэлтээр тухайн улс орны аюулгүй байдал, эдийн засгийн өсөлт, нийгмийн сайн сайхан байдал хангагдаж байдаг. Иймээс татварын эрх зүйн орчныг сайжруулах, иргэдэд хүрч үйлчлэх механизмыг боловсронгуй болгох зэргээр татварын байгууллагын үйл ажиллагаанд нээлттэй, ил тод, тэгш, шударга байх зарчмуудыг мөрдөх ёстой. Монгол улсын УИХ, Засгийн газар, Сангийн Яам, Монголын татварын алба зэрэг институцийн байгууллагуудын зүгээс татварын хууль тогтоомжийг тасралтгүй сайжруулан шинэчлэхтэй зэрэгцүүлэн татварын үйл ажиллагааг татвар төлөгчдөд ойртуулах, хялбаршуулах, цахимжуулах үүрэгт анхаарал хандуулан тодорхой бодлогын шинж чанартай ажлуудыг хийсээр байна. Эдгээрийн нэг нь татварын шинэчлэлийн хүрээнд татвар төлөгчийн эрсдэлийг тооцоолох арга ажиллагааг цахимжуулсан явдал юм.

Байгууллагад учрах татварын эрсдэлийг татварын байгууллагаас удирдан зохион байгуулж, хуулийн хөөн хэлэлцэх хугацаанд буюу 5 жилд 1 удаа татварын хяналт шалгалтад хамруулах бодлого үйлчилдэг байсан бол татварын шинэчлэлийн хүрээнд байгууллага өөрийнхөө эрсдэлийг удирдаж, хяналт шалгалтад хамрагдах эсэхээ зохицуулдаг механизм хэрэгжиж эхлээд байна. Үүний үр дүнд татварын хяналт шалгалтын тоо 10 дахин буурч, эрсдэлтэй татварын төлөгчдийг оновчтой тодорхойлох, татварын хяналт шалгалттай холбоотой гарах зардлыг бууруулах, цаг хугацаа хэмнэх, татвар төлөгчдийн татварын бүртгэл, тайлагнал, төлөлттэй холбоотой эерэг хандлага нэмэгдэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зэрэг давуу талууд бий болж байна. Үүнд 2020 оноос үйл ажиллагаандаа нэвтрүүлж, суурилуулан хэрэглэж буй их өгөгдөлд суурилсан мэдээллийн технологийн шинэчлэлт томоохон үүрэгтэй ба үүний үр дүнд татвар төлөгчдийн эрсдэлийг үнэлэх, татварын скоринг үнэлгээ хийх боломж бүрдсэн.

Судалгаа

Монгол улсад татварын алба үүссэн цагаас хойш татварын шинэчлэлтийг тасралтгүй хийсээр ирсэн ба үүнтэй зэрэгцүүлэн их өгөгдлийн бааз (big data)-ыг үүсгэсээр ирсэн. Үүнд 1994 онд VAT, MS-DOS, Dbase зэрэг татварын төлөгчийн бүртгэл, худалдааны албан татварын программыг, 2001 онд ТАХАСТ Windows Application Oracle 8i DB татварын хуулийн хэрэгжилтийг хангах системийг, 2009 онд ETAX Web Application Oracle 9i DB цахим татварын системийг, 2012 онд ETAX Web Application Oracle 11g DB тоон гарын үсгийн систем, 2016 онд EBARIMT Web Application,

Mobile Apps Oracle 12c DB цахим төлбөрийн баримтын системийг, 2019 онд TAIS Web Application Oracle 19c DB татварын удирдлагын нэгдсэн системийг, 2020 онд TAX-TUB Mobile App цахим татварын шинэчилсэн системийг, 2021 онд их өгөгдлийн санд “Machine learning” алгоритм ашиглах TALENT, CLOUDERA зэрэг технологийг, 2022 онд их өгөгдлийн санд суурилсан мэдээллийн нэгдсэн дашбоард зэргийг нэвтрүүлээд байгаа бөгөөд цаашид өгөгдлийн санг бэлтгэх Data Warehouse үүсгэх, мэдээллийн аюулгүй байдлыг олон улсын стандарт ISO 27001:2022-д нийцүүлэх ажлуудыг хийж байна. Эдгээр цахим технологийн нэвтрүүлэлт, цахим шилжилтийн үр дүнд их өгөгдлийн баазад суурилсан эрсдэлийн загварчлалыг хөгжүүлж, өнөөдөр үйл ажиллагаандаа машин сургалтын загварчлалуудыг ашигласаар байна.

Түүнчлэн 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан Татварын Ерөнхий Хуульд Эрсдэлийн удирдлагатай холбоотой ерөнхий зарчим, эрсдэлийн удирдлагын арга хэмжээг хэрэгжүүлэх үе шат, эрсдэлийн удирдлагатай холбоотой журмын баталгаажуулалт (УИХ, 2019) зэргийг тусгасан бол Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 305 дугаар тушаалаар батлагдсан “Татварын албаны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журам”-д эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх, удирдах, хянах зэрэг үйл ажиллагааг зохицуулсан.

Татварын скоринг нь татварын албанаас татвар төлөгчдийн хууль тогтоомжийн мөрдөлт, биелэлтэд өгч буй үнэлгээ бөгөөд үүнд үндэслэн татвар төлөгчийг цаг хугацаандаа татвараа үнэн зөв тайлагнах, татвар төлөх үйл явцыг дэмжих, урамшуулах, хяналтыг хэрэгжүүлэх зорилготой юм. Татварын скорингийг улс орон бүр өөрийн онцлогт тохируулан хөгжүүлж ирсэн байна.

Тухайлбал, АНУ тухайн татвар төлөгчийн орлого, ашиг, хөрөнгө, өмч, зах зээлд эзлэх байр суурь, хэмжээ, нэгж хувьцаанд ногдох ашиг, хөрөнгө оруулалтын өгөөж зэрэг олон үзүүлэлтийг эрэмбэлэн Big500 том бизнесийн жагсаалтыг гаргадаг ба үүгээр нь дамжуулан Credit scoring system буюу хувь хүний зээлийн системтэй нь уялдуулж, үр дүнтэй ашигладаг байна. Харин БНХАУ Social credit scoring system буюу татвар төлөгчийн зан төлөв, хуулийн мөрдөлтийг илэрхийлдэг системийг нэвтрүүлэн хэрэглэж байгаа бөгөөд татвараа цаг тухайд нь төлсөн татвар төлөгчийн скоринг өндөр илэрхийлэгддэг. Сингапур улс татварын хууль тогтоомж сайн мөрдсөн татвар төлөгчийг урамшуулах системийг ашигладаг бол Австрали улс хууль тогтоомж мөрдөж буй хандлагыг илүү илэрхийлэх системтэйн дээр уг систем нь татвар төлөгч нарыг сэрэмжлүүлэх хөтөлбөртэй байдаг. Бразил улс Cadastro Positivo Fiscal буюу хууль даган мөрдөлтийн түүхийг үнэлэх замаар татвар төлөгчдийг хөнгөлөлттэй зээл, засгийн газрын тусламж, дэмжлэг, тэтгэмжид хамруулах бодлогыг баримтлах скорингийн системтэй бол БНСУ-ын хувьд мөн хууль даган

мөрдөлтийн түүхийг үнэлэх системтэй байна. БНСУ-ын хувьд үнэлгээ сайн бол аудит, хяналт шалгалтын давтамжийг багасгах, бууруулах, хялбаршуулсан тайлагналын системийг санал болох зэрэг давуу талыг татвар төлөгчдөд үзүүлдэг байна. Монгол улсын хувьд БНХАУ-ын загварт тулгуурлан өөрийн орны онцлогт тохируулан хөгжүүлж, нэвтрүүлсэн.

Монгол улсын хувьд татварын эрсдэл, скоринг үнэлгээг хийхдээ дараах хүчин зүйлүүдийн нийт дүнгээр ерөнхий эрсдэлийн үнэлгээг тодорхойлж байна. Үүнийг томьёолбол дараах байдалтай байна. (Кобахидзе, 2023)

$$R = a_1 * R_1 + a_2 * R_2 + a_3 * R_3 + a_4 * R_4 + a_5 * R_5$$

Үүнд:

- R_1 Татварын эрсдэлийн үнэлгээ
- R_2 Татварын скоринг
- R_3 Татвар ногдох болон хасагдах зардлын таамаглал
- R_4 Татварын тайлангийн харьцаа, үзүүлэлтүүдийн зохистой байдал
- R_5 Татварын хяналт шалгалтын зөрчлийн дундаж таамаглал
- $a_{1,2,3,4,5}$ Үзүүлэлт тус бүрд хамаарах хувийн жин

Ерөнхий эрсдэлийн үнэлгээг диаграммд харуулсан 5 хүчин зүйлсийг холбогдох хувийн жингээр нь үржүүлэн нийлбэрийг гаргах замаар тооцох ба дараах байдлаар тодорхойлно.

Үүнд:

- $0 < \text{эрсдэлийн оноо} < 25$ бол “Хүлээн зөвшөөрөх”
- $25 < \text{эрсдэлийн оноо} < 50$ бол “Бага”
- $50 < \text{эрсдэлийн оноо} < 75$ бол “Дунд”
- $75 < \text{эрсдэлийн оноо} < 100$ бол “Өндөр”

Татварын эрсдэлийн үнэлгээ нь:

$$R_1 = a_1 * r_1 + a_2 * r_2 + a_3 * r_3 + a_4 * r_4 + a_5 * r_5 + a_6 * r_6$$

- r_1 Орлогын албан татварын тайлан дахь татвар ногдох орлогод суурилсан дэд эрсдэлийн оноо
- r_2 Орлогын албан татварын тайлан дахь хасагдах зардалд суурилсан дэд эрсдэлийн оноо
- r_3 Татварын тайлагнал болон хөндлөнгийн эх үүсвэрийн мэдээллийн зөрүүд суурилсан дэд эрсдэлийн оноо
- r_4 Санхүүгийн тайлагнал, санхүүгийн шинжилгээнд суурилсан дэд эрсдэлийн оноо

- r_5 Логистик регрессийн шинжилгээнд суурилсан дэд эрсдэлийн оноо
- r_6 Салбарын дунджийн хазайлтад суурилсан дэд эрсдэл

r_1, r_2 нь байгууллагуудыг том, жижиг, дунд, бичил гэсэн 4 сегментэд хуваан авч үзэж байгаа ба улмаар татвар ногдох орлого, хасагдах зардлын дүнг харгалзан сегмент, эдийн засгийн салбарын ангилал дотор нь эрэмбэлсэн үзүүлэлт бөгөөд их орлоготой бол их оноотой байна.

r_3 нь татварын тайлангуудаар тайлагнасан дүнгүүдийн хоорондын зөрүү их байх тусам энэ оноо их гарна гэсэн логиктой бөгөөд санхүүгийн тайлан, төлбөрийн баримт, гаалийн мэдээ зэрэг хөндлөнгийн эх сурвалжийн мэдээллийг ашигладаг.

r_4 нь Том сегментийн татвар төлөгчийн санхүүгийн тайланд үндэслэн тооцсон санхүүгийн тогтвортой байдал, төлбөрийн чадварын харьцаануудыг тодорхойлон зэрэглэл тогтооно.

r_5 нь Бүртгэл, тайлагнал, төлөлт, хяналт шалгалтын түүхэн мэдээлэлд үндэслэж регрессийн шинжилгээ хийгдэж байгаа. Хяналт шалгалтын актын үр дүнг үндэслэн магадлалын утга эрсдэлийн оноог тооцно.

r_6 нь Татвар төлөгчийн татварын өмнөх ашгийн түвшин болон бодит татварын хувь хэмжээг тухайн татвар төлөгчийн эдийн засгийн салбарын дундаж түвшний хазайлтыг ашиглан тооцно.

Ерөнхий эрсдэлийн үнэлгээнд тухайн байгууллагын үйл ажиллагааны бүртгэл тайлагналтай холбоотой хүчин зүйлсээс гадна салбарын эрсдэлийн дундаж, хөндлөнгийн мэдээлэл зэрэг бусад хүчин зүйлсийг авч үзэж буйгаараа онцлогтой ба үүнд Монголын татварын алба хиймэл оюун ухааныг ашиглаж байна. Татварын эрсдэлийн үнэлгээ нь татвар төлөгчийн тайлагнал өөрчлөгдөх, татварын алба эрсдэл тооцох шалгуур үзүүлэлтээ боловсронгуй болгох, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудаас мэдээлэл ирэх, татвар төлөхөөс зайлсхийх үйлдэл гаргах, ижил салбарт үйл ажиллагаа явуулж буй татвар төлөгчдийн тайлагналын түвшин сайжрах зэргээр өөрчлөгддөг.

Татварын скоринг:

1. Татварын төлөгчийн үндсэн бүртгэл,
2. Татварын тайлагнал
3. Татвар ногдуулалт
4. Татвар төлөлт
5. Хяналт шалгалт
6. Санхүүгийн тайлан
7. Өмнөх жилийн скоринг гэсэн үндсэн хүчин зүйлүүдийн сүүлийн 3 жилийн үзүүлэлтээр тодорхойлогдоно.

Эдгээр мэдээллийг цахим татварын систем, цахим баримын систем, татварын албаны дотоод удирдлагын системээр дамжуулан цуглуулдаг. Татварын скорингийн үнэлгээ нь А, В, С, D гэсэн үнэлгээтэй байх ба дараах үзүүлэлтээр тайлбарлагдана.

Үүнд:

- А (90 – 100 оноо) үнэлгээ нь татвар төлөгчийн нэр хүндийн баталгаа болохоос гадна төрөл бүрийн урамшууллын бодлогод хамрагдах боломжтой
- В (80 – 90 оноо) үнэлгээ
- Хэрэв тухайн байгууллага тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй болон сүүлийн 4 жил татвар ногдох орлогогүй байсан бол автоматаар С (70 – 80 оноо) үнэлгээ авах ба хамгийн ихдээ 75 оноо байна.
- Групп компаниудын хувьд нэг гишүүг компани D (0 – 70 оноо) үнэлгээ авбал тухайн групп тэр чигтээ D үнэлгээ авна.
- D үнэлгээ авсан байгууллага татварын хяналт орох магадлал өндөр болно. D Үнэлгээ авбал дараагийн 3 жилдээ А үнэлгээ авахгүйн дээр тогтмол татварын хяналт шалгалтад хамрагдах, эхний ээлжид татварын өрийг нэн тэргүүнд барагдуулна.

Татварын скорингийн үнэлгээг нийт 106 оноос эхлэн тооцох ба шалгуурын бүлэг тус бүрийн хувьд хасаж тооцох оноог дараах хүснэгтээр харуулав. (МТА, 2023)

Хүснэгт 1. Татварын скорингийн үнэлгээний үзүүлэлт

| Үндсэн үзүүлэлт | Дэд үзүүлэлт | 3-р түвшний үзүүлэлт | Дүн |
|-----------------------|---|--|-----|
| 01. Үндсэн бүртгэл | 0101. Үйл ажиллагаа явуулсан жил | 010101. 3 жилээс богино хугацаанд үйл ажиллагаа явуулсан | -11 |
| 02. Татвар тайлагналт | 0201. ААНОАТ | 020101. ААНОАТ тайлан огт илгээгээгүй | -11 |
| | | 020102. ААНОАТ тайлан хоцроосон | -5 |
| | 0202. НӨАТ | 020201. НӨАТ төрлөөр бүртгэлгүй (Х бичлээс бусад) | -11 |
| | | 020202. НӨАТ тайлан огт илгээгээгүй | -11 |
| | | 020203. НӨАТ тайлан дунджаар 2 дээш хоног хоцроосон | -5 |
| | | 020204. НӨАТ тайлан дутуу илгээсэн | -11 |
| 0203. Суутган ТТ11 | 020301. Суутган тайлан (бичлээс бусад сегмент Х тайлан) | -11 | |
| 03. Үйл ажиллагаа | 0301. Үйл ажиллагаа явуулаагүй | 030101. ААНОАТ + НӨАТ <= 0 | 75 |

| | | | |
|---|---|--|------|
| 04. Татвар ногдуулалт | 0401. ААНОАТ | 040101. ААНОАТ алдагдалтай тайлан (сүүлийн 3 жил) | -5 |
| | 0402. НӨАТ | 040201. НӨАТ буцаан олголттой тайлагнасан (сүүлийн 3 жил) | -5 |
| 05. Татвар төлөлт | 0501. Татвар төлөлт | 050101. өрийн хэмжээ ***** F дээш, огт төлөөгүй, (сегментээр) | -11 |
| | | 050102. өрийн хэмжээ ***** F дээш, төлөлттэй, (сегментээр) | -5 |
| | | 050103. 2 жилээс дээш өртэй | -5 |
| 06. Хяналт шалгалт | 0601. Сүүлийн 4 жилийн хяналт шалгалт | 060101. нөхөн татвар = 0 | 5 |
| | | 060102. нөхөн татвар ***** F дээш, (сегментээр) | -5 |
| 07. Өмнөх жилийн үнэлгээ | 0701. Өмнөх жилийн үнэлгээ | 070101. А | 3 |
| | | 070102. В | 1 |
| | | 070103. С | -3 |
| | | 070104. D | -11 |
| 08. Хий бичилт | 0801. Хий бичилт | 080101. Хуурамч падаан үйлдсэн | 60 |
| | | 080102. Хуурамч падаан худалдан авсан (<***%) | 60 |
| 09. Санхүүгийн тайлан | 0901. Санхүүгийн тайлан | 090101. Санхүүгийн тайлан илгээгээгүй | -11 |
| | | 090102. Өр хөрөнгийн харьцаа хэт их (өр ихтэй) | -4 |
| | | 090103. Хөрөнгийн өгөөж (ROA) хэт бага (<***%) | -4 |
| | | 090104. Нийт хөрөнгөгүй эсвэл эздийн өмчгүй | -3 |
| | | 090105. Ашигт ажиллагаа (ROE) хэт бага (<***%) | -4 |
| 10. Групп компани | 1001. Групп компани | 100101. Групп компанийн нэг компани нь D үнэлгээтэй бол бусад нь D үнэлгээ авна | 60 |
| Үзүүлэлтийн бүлэг тус бүрийн хувьд хасагдах дээд боломжит оноо | | 01. Үндсэн бүртгэл | -11 |
| | | 02. Татвар тайлагналт | -38 |
| | | 04. Татвар ногдуулалт | -10 |
| | | 05. Татвар төлөлт | -16 |
| | | 06. Хяналт шалгалт | -5 |
| | | 07. Өмнөх жилийн үнэлгээ | -11 |
| | | 09. Санхүүгийн тайлан | -15 |
| Нийт хасагдах оноо | | | -106 |
| Үнэлгээг шууд бууруулах нөхцөл | | 03. Үйл ажиллагаа явуулаагүй | 75 C |
| | | 08. Хий бичилт | 60 D |
| | | 10. Групп компани (нэг ААН D үнэлэгдвэл группын хэмжээнд D) | 60 D |

Татварын скоринг, татварын эрсдэлийн үнэлгээгээ сайжруулж, зохистой удирдахын тулд татвар төлөгч татварын хууль тогтоомжийг зохистой мөрдөж, татвар ногдлоо үнэн зөвөөр тооцож, татварын тайланг хугацаанд нь тайлагнаж, татвараа хугацаанд нь төлж байх хэрэгтэй юм. Сүүлийн 3 жилд А үнэлгээ авахгүй болсон D үнэлгээтэй компаниудын хувьд:

- Тухайн бизнесийг 3 жил үйл ажиллагаа явуулсны дараа тогтворждог судалгаа байдаг тул татварын төлөгчийн үндсэн бүртгэлийн оноонд өөрчлөлт орохгүй
- Татварын тайлагналын хувьд татварын тайланг хуульд заасан хугацаанд ирүүлэх
- Татвар ногдуулалтын хувьд татварын тайланг үнэн зөвөөр илгээх, татварын тайлан хоорондын уялдаа хангагдсан байх
- Татвар төлөлтийн хувьд хуульд заасан хугацаанд татвар төлөх, татварын өр үүсгэхгүй байх
- Хяналт шалгалтын хувьд зөв тайлагнасан бол оноо алдахгүй, үнэлгээнд өөрчлөлт орохгүй байж үнэлгээ дээшилнэ.

Татварын скорингийг тооцоолох аргачлал нь дараах горимоор хэрэгжиж байна.

Үүнд:

1. Тайлангийн үзүүлэлт таамаглах загвар: Татвар ногдох орлого болон хасагдах зардлаас хамааруулан татвар төлөгчийн борлуулалтын орлогыг Simple gradient boost regression алгоритмаар таамагладаг ба тайлангийн үзүүлэлт зөрүүтэй тохиолдолд татвар төлөгчид мэдэгдэж тайланг нь залруулах арга хэмжээг авах механизм юм. 2022 оны судалгаагаар 1,462 тайланг залруулсан байна. Энэ нь татвар төлөгчийн борлуулалтын орлого, зардал, ашгийн түвшнийг эдийн засгийн салбарын ангиллаар урьдчилж таамаглаад татвар төлөгчдөд эрсдэлийн оноонд дэд үзүүлэлт болгон харуулж өгнө. Машин технологийн аргыг ашиглан эдийн засгийн үзүүлэлтүүд болох ДНБ, далд эдийн засгийн хувь хэмжээ, татварын албаны түүхэн дата-г ашиглан таамаглалыг дэвшүүлэн татвар төлөгчдөд мэдээлдэг.
2. Тайлангийн харьцаа, үзүүлэлтүүдийн уялдаатай байдлыг шалгах загвар: Энэ нь санхүү татварын тайлангийн зохистой харьцаа байгаа эсэхийг шалгадаг загвар. Ингэснээр тухайн бизнес томроогүй, бизнес өргөжөөгүй эсвэл хумигдаагүй, тогтмол байна гэдгийн нэгдүгээр шалгуур. Гэтэл орлого тогтмол боловч зардал яагаад өсөж байгаа вэ, бизнесийн тэлэлт хийгээгүй, хүн нэмж ажилд аваагүй, салбарууд нээгээгүй ч яагаад зардал өсөөд байгааг, эсвэл эсрэгээрээ зардал тогтмол байхад орлого яагаад буураад байгаа вэ гэдгийг санхүүгийн харьцаагаар шалган татвар төлөгчдөд мэдэгдэж байна. Энэ нь таны тайлангуудын харьцаа асуудалтай байна, та эргэж нэг хараач гэж мэдэгдэж байгаа юм. Ингэснээр татвар төлөгч тайлангаа засварлаж зөв болгох нь хяналт шалгалтад хамруулахаас илүү

үр дүнтэй гэдэг нь судалгаанаас харагдаж байна. 2022 онд орлого тогтмол, зардал өссөн эсвэл зардал тогтмол, орлого буурсан, орлого зардлын өсөлтийн харьцаа уялдаатай, зөвхөн орлого өссөн эсвэл зөвхөн зардал буурсан зэрэг боломжит хувилбаруудыг түүвэрлэн татвар төлөгчдөд тайлан засварлах мэдээлэл хүргэхэд 33 нь тайлангаа засварлаж, орлого нэмж тайлагнасан бол 28 татвар төлөгчийг хяналт шалгалтад хамруулж тодорхой хэмжээний төлбөр ногдуулсан байна.

3. Хяналт шалгалтаар илрэх зөрчлийг таамаглах загвар: Түүхэн өгөгдөлд үндэслэн машин сургалтын Random forest алгоритмаар зөрчил илрэх магадлал болон дүнг тооцоолно. Энэ нь тухайн татвар төлөгчийг татварын хяналт шалгалтад хамруулахад хэдий хэмжээний зөрчил илрэх вэ гэдгийг урьдчилан таамаглаж буй загвар юм. Татварын алба маш их хэмжээний дата баазтай, татвар төлөгч нь өмнө нь шалгагдаж байсан зөрчлийн сангийн мэдээллүүд нь татварын хууль болгоноор татвар төлөгч бүрээр архивлагдсан байдаг ба уг зөрчлийн сан дээр таамаглах, машин суралцах технологи ашиглаад сүүлийн 3 жилийн мэдээллээр загварчлалуудыг хийхэд оновчлол нь 87% -тай байна.

2022 оны жилийн эцсээр 246,300 орчим аж ахуйн нэгж улсын хэмжээнд байна. Үүнээс 86,356 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг гэсэн судалгаа байна. Монголын Татварын албанаас өгч буй мэдээллээр том, дунд, жижиг, бичил гэсэн дөрвөн сегментээр ангилсан нийтдээ 230,340 аж ахуйн нэгж байна. Үүнд:

- Том сегментэд зургаан тэрбумаас дээш татвар ногдуулах орлоготой, 25%-ийн ААНОАТ төлөх, улирал бүр тайлагнах 908 аж ахуйн нэгж
- Дунд сегментэд 1.5 – 6 хүртэл тэрбум татвар ногдуулах орлоготой, 10%-ийн ААНОАТ төлөх, 2 удаа тайлагнах 2,694 аж ахуйн нэгж
- Жижиг сегментэд 50 саяас 1.5 тэрбум хүртэлх татвар ногдуулах орлоготой, 10 болон 1%-ийн ААНОАТ төлөх, хоёр удаа тайлагнах 36,201 аж ахуйн нэгж
- Бичил сегментэд 50 сая хүртэлх татвар ногдуулах орлоготой 1%-ийн ААНОАТ төлөх, жилд нэг удаа тайлагнах 190,537 аж ахуйн нэгж байна.

Эдгээрээс Монголын Татварын албанаас тодорхойлсноор өндөр эрсдэлтэй 556, дунд эрсдэлтэй 9,063, бага эрсдэлтэй 31,560, хүлээн зөвшөөрөх эрсдэлтэй 203,538, эрсдэлгүй 5,016 аж ахуйн нэгж байна. Мөн аж ахуйн нэгжүүдээс гадна том орлоготой, бизнесийн зорилгоор үйл ажиллагаа явуулдаг 893,926 иргэн Монголын Татварын албанд бүртгэлтэй байгаа бөгөөд үүнээс том сегментэд 100 иргэн, дунд сегментэд 200 иргэн, жижиг сегментэд 1,200 иргэн, бичил сегментэд 892,426 иргэн ангилагдсан байна.

Том сегментийн 899 компанийн 17 хувь нь өндөр, 63 хувь нь дунд, 13 хувь нь бага, 7 хувь нь хүлээн зөвшөөрөх эрсдэлтэй байна. Төсвийн 70 хувийг бүрдүүлэгч том компаниуд татварын эрсдэл өндөр байна гэдэг нь байнга татварын хяналт шалгалтад орж байх ёстой болохыг харуулж байна.

Хүснэгт 2. Татварын эрсдэлийн үнэлгээний дүн

| Сегмент | А | | В | | С | | D | | Эрсдэлгүй | | Нийт |
|---------|-----|------|-------|------|--------|------|---------|------|-----------|------|---------|
| | Тоо | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь | |
| Том | 156 | 17% | 562 | 63% | 114 | 13% | 67 | 7% | - | 0% | 899 |
| Дунд | 272 | 10% | 1,775 | 66% | 556 | 21% | 97 | 4% | - | 0% | 2,700 |
| Жижиг | 101 | 0% | 5,637 | 15% | 21,587 | 59% | 9,204 | 25% | 164 | 0% | 36,693 |
| Бичил | 27 | 0% | 1,089 | 1% | 9,303 | 4% | 194,170 | 93% | 4,852 | 2% | 209,441 |
| Нийт | 556 | | 9,063 | | 31,560 | | 203,538 | | 5,016 | | 249,733 |

Эх сурвалж: <https://business.mn/2023/09/11/tatvariin-albanaas-nevtruulsen-tatvariin-skoring-gej-yuu-ve/>

Том сегментийн 63% нь, дунд сегментийн 66% дунд эрсдэлтэй гэж үнэлэгджээ. Харин жижиг сегментийн 59% нь бага эрсдэлтэй бол бичил аж ахуйн нэгжийн 93% нь хүлээн зөвшөөрөгдөх эрсдэлтэй ажээ. Эндээс том болон дунд аж ахуйн нэгжүүд татварын эрсдэл ихтэй, бичил сегментийн аж ахуйн нэгжүүд эрсдэлгүй байгааг судалгааны үр дүн харуулсан байна. Эндээс Монгол улсад компаниуд томрох тусам эрсдэл ихтэй болж байгаа мэт ойлголт үүсэж байна.

Татварын скорингийн хувьд том сегментийн 917 аж ахуйн нэгжийг скоринг оноог харахад 8% нь А, 54% нь В, 36 % нь С, 4% нь D үнэлгээтэй байна.

Хүснэгт 3. Татварын скорингийн үнэлгээний дүн

| Сегмент | А | | В | | С | | D | | Нийт |
|---------|--------|------|---------|------|--------|------|-------|------|---------|
| | Тоо | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь | |
| Том | 74 | 8% | 483 | 54% | 321 | 36% | 39 | 4% | 917 |
| Дунд | 256 | 10% | 1,260 | 47% | 1,018 | 38% | 89 | 3% | 2,623 |
| Жижиг | 4,088 | 14% | 14,435 | 39% | 9,794 | 27% | 1,733 | 5% | 30,050 |
| Бичил | 9,079 | 6% | 112,640 | 54% | 18,817 | 9% | 3,304 | 2% | 143,840 |
| Нийт | 13,497 | | 128,818 | | 29,950 | | 5,164 | | 177,430 |

Эх сурвалж: <https://business.mn/2023/09/11/tatvariin-albanaas-nevtruulsen-tatvariin-skoring-gej-yuu-ve/>

Дээрх хүснэгтээс харахад компаниудын дийлэнх нь В үнэлгээтэй байна.

2022 оны жилийн эцсийн тайлангийн өгөгдлийг 2023 оны 5 сард скоринг үнэлгээ хийж мэдэгдэхэд 101,391 татвар төлөгчийн татварын скоринг үнэлгээ сайжирсан, 54,577 татвар төлөгчийн татварын скоринг үнэлгээ өөрчлөгдөөгүй байна. (МТА, 2023)

Хүснэгт 4. Татварын скорингийн үнэлгээний харьцуулалт

| Сегмент | А | | В | | С | | D | |
|---------|--------|--------|--------|--------|---------|--------|--------|--------|
| | Өмнө | Дараа | Өмнө | Дараа | Өмнө | Дараа | Өмнө | Дараа |
| Том | 188 | 396 | 178 | 159 | 266 | 195 | 257 | 154 |
| Дунд | 523 | 1,211 | 600 | 580 | 595 | 441 | 882 | 437 |
| Жижиг | 6,821 | 11,075 | 7,538 | 9,646 | 6,641 | 7,928 | 9,078 | 6,584 |
| Бичил | 11,781 | 28,553 | 7,155 | 36,147 | 103,603 | 44,765 | 20,894 | 31,516 |
| НИЙТ | 19,313 | 41,235 | 15,471 | 46,532 | 111,105 | 53,329 | 31,111 | 38,691 |

Эх сурвалж: Монголын татварын алба, 2023 он

Орхон аймгийн Татварын хэлтсийн судалгаагаар хуулийн шинэчлэлтэй холбоотойгоор 2016-2023 онуудын хяналт шалгалтын дүнг харьцуулахад дараах үр дүн гарсан байна.

Хүснэгт 5 Татварын хяналт шалгалтад хамрагдалтын мэдээлэл

/Орхон аймгийн дүнгээр/

| Хяналт шалгалтад хамрагдсан татвар төлөгчдийн тоо /хуучин хуулиар буюу 5 жилд 1 удаа/ | | | Хяналт шалгалтад хамрагдсан татвар төлөгчдийн тоо /шинэ хуулиар буюу эрсдэлээр/ | | |
|---|--------------|----------------------|---|--------------|----------------------|
| Он | Шалгасан тоо | Шалгаснаас зөрчилгүй | Он | Шалгасан тоо | Шалгаснаас зөрчилгүй |
| 2016 | 247 | 43 | 2020 | 68 | - |
| 2017 | 242 | 34 | 2021 | 78 | - |
| 2018 | 239 | 28 | 2022 | 45 | - |
| 2019 | 251 | 41 | 2023 | 77 | - |
| Дүн | 979 | 146 | Дүн | 268 | - |

Эх сурвалж: Орхон аймгийн Татварын хэлтэс, хяналт шалгалтын мэдээлэл

Судалгаанаас дүгнэхэд 2016-2019 онд татварын шинэчлэлт хийгдээгүй байхад эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийдэггүй байснаас жилд дунджаар 245 аж ахуйн нэгжид хяналт шалгалтыг хэрэгжүүлж, үүнээс дунджаар 37 аж ахуйн нэгж ямар нэгэн татварын зөрчил гаргаагүй байна. Энэ нь татварын хяналт шалгалтын ажилтны ажлын ачааллыг нэмэгдүүлэх, цаг хугацаа алдах, хяналт шалгалттай холбоотой зардлыг өсгөх зэрэг хүндрэлийг үүсгэж байсан байна. Харин 2020 оноо татварын системд шинэчлэлт хийгдсэнтэй холбоотойгоор зөвхөн эрсдэлтэй татвар төлөгчдийг их өгөгдлийн сангийн мэдээлэлд тулгуурлан машин технологиор сонгон хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд сонгогдон хяналт шалгалтад хамрагдсан бүх татвар төлөгч нар ямар нэгэн зөрчилтэй байна. Энэ нь Big Data төслийг хэрэгжүүлсний үр дүнд татвар төлөгчийн эрсдэлийг

оновчтой тодорхойлж, татварын хяналт шалгалтад хамрагдах татвар төлөгчийг үнэн зөв таамаглах боломжийг бий болгож чадсан болохыг гэрчилж байна.

Түүнчлэн 2023 онд татварын хяналт шалгалтад хамрагдсан 46 татварын төлөгчөөс татварын эрсдэлтэй холбоотой санал асуулгыг авахад дараах үр дүн гарч байна.

| <i>Хүснэгт 6. Татвар төлөгчийн судалгааны дүн /Орхон аймаг/</i> | |
|---|---|
| N* | Асуултын агуулга |
| | Та эрсдэлийн онооны талаар ойлголттой юу? |
| 1 | Тийм -32 Үгүй -14 |
| | Тийм бол эрсдэлийн оноогоо бууруулах талаар залруулга хийсэн үү? |
| 2 | Тийм -8 Үгүй -38 |
| | Танай байгууллагад ногдуулсан төлбөрийн дүн хир бодитой гэж бодож байна? |
| 3 | Тийм -40 Үгүй -6 |
| | Та шалгалтаар илэрсэн зөрчлөө хүлээн зөвшөөрч байна уу? |
| 4 | Тийм -42 Үгүй -4 |
| | Эрсдэлийн онооны талаар ойлголт тань хяналт шалгалтын дараа өөрчлөгдсөн үү? |
| 5 | Тийм -42 Үгүй -4 |
| НИЙТ САНАЛЫН ХУУДАС-46 | |
| | ТИЙМ- 164 |
| | ҮГҮЙ- 66 |

Үүнд:

1. Татварын эрсдэлийн үнэлгээ, скорингийн талаар судалгаанд хамрагдсан татварын төлөгчийн 70% нь тодорхой ойлголттой байгаа бол 30% нь мэдээлэл, ойлголтгүй байна. Орхон аймгийн татварын хэлтсээс 2020-2023 онуудад нийт давхардсан тоогоор 19 удаагийн танхимын сургалтаар 1,200 орчим татвар төлөгчдөд мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан бөгөөд үгүй гэж хариулсан 14 татвар төлөгчийн 9 нь Х тайлан илгээдэг татвар төлөгчид байна. Энэ нь үйл ажиллагаа явуулахгүй байгаа татварын он дамнасан өр ихтэй, нягтлан бодогч тогтвор суурьшилгүй татвар төлөгч байгууллагууд байгаа бөгөөд үүнээсээ улбаалан аливаа мэдээллээс хоцорч байна.
2. Татварын эрсдэлийн оноогоо бууруулахад чиглэсэн залруулгыг судалгаанд хамрагдсан татвар төлөгчийн 17% нь хийсэн гэсэн судалгааг өгчээ. Үүний шалтгааныг ярилцлагын аргаар түүвэрлэн тодруулахад

өмнөх онуудын алдаа зөрчлүүд залруулагдахгүй болж, залруулах тайланг хугацаа хэтэрсэн, залруулах арга, аргачлалаа мэдэхгүй байх, эрсдэлийг бууруулах боломжуудыг тодорхойлж чадахгүй байх, цахим анхан шатны баримтуудыг бүрдүүлээгүй байх зэрэгтэй холбоотой байна.

3. Татварын хяналт шалгалтаар нийт судалгаанд хамрагдсан татварын төлөгчдийн 87% нь тодорхой хэмжээний нөхөн татвар, төлбөр, торгууль, алданги зэргийг төлүүлэхээр ногдуулсан ба төлбөрийг үндэслэлтэй, бодитой тооцоологдсон гэдэгтэй санал нийлсэн байна. Уг төлбөрийн тооцоолол дүнг хүлээн зөвшөөрөөгүй татвар төлөгчид татварын маргаан таслах зөвлөлд шилжүүлэгдэж байна. Татварын зөрчлөө 91% нь хүлээн зөвшөөрч байгаа бол 9% нь үл хүлээн зөвшөөрсөн байна. 2 татвар төлөгчийн хувьд зөрчлөө хүлээн зөвшөөрсөн ч ногдуулсан төлбөрийн дүнг хүлээн зөвшөөрөөгүй байна.
4. Хяналт шалгалтад хамрагдсан татвар төлөгчдөд татварын байгууллагын зүгээс татварын эрсдэлийн үнэлгээ, татварын скорингийн талаар ганцаарчилсан зөвлөгөөг өгдөг бөгөөд 91% нь ойлголттой болсон үр дүн гарчээ. 4 татвар төлөгчийг хувьд үр дүнг хүлээн зөвшөөрөөгүй, ойлгохыг хүсэхгүй байгаа зэрэг татвар төлөгчийн хандлагатай холбоотой асуудал үүссэн байна.

Түүнчлэн А үнэлгээтэй татвар төлөгчдийг урьж ээлжит сургалт, зөвлөгөөнд оролцуулан тэдний туршлагыг бусад татвар төлөгчдөд хүргэх, мэдээлэхэд нийтлэг дараах туршлага, зөвлөмжүүдийг санал болгож байна. Үүнд:

- Тайланг богино хугацаанд цаг тухайд тогтмол хийж байх, үүнд нийцүүлэн хамгийн сайн санхүүгийн программтай, сайн боловсруулагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, санхүүгийн үйл ажиллагааны дотоод журамтай байх;
- Тайлан хоорондын уялдаа холбоог хангах, өөрөөр хэлбэл тайлан хүргүүлдэг субъектүүдийг ижил мэдээллээр хангах, тайланг цаг хугацаанд нь илгээх;
- Татвараа цаг хугацаанд нь төлөх;
- Харилцагч байгууллагуудтайгаа мэдээлэл, баримт эргэлтээ түргэсгэх, уялдаа холбоотой ажиллах, баримтыг цаг хугацаанд нь бүрдүүлэх;
- Нягтлан бодогч хугацаандаа ажил үүргээ гүйцэтгэхэд удирдлагын дэмжлэг маш чухал, иймээс удирдлагууд хийж буй гэрээ хэлцэл, ажил гүйлгээтэй холбоотой мэдээллийг тухай бүр нягтлан бодогч нарт иж бүрэн гаргаж өгөх;
- Цагийн менежмент, хувийн сахилга батаа татвар төлөгч нар дээшлүүлэх;

ДҮГНЭЛТ

Энэхүү өгүүллийн хүрээнд татварын шинэчлэлт, цахим шилжилтүүд хийгдснээр дараах үр дүн бий болж байна гэж дүгнэлээ. Үүнд:

1. Татвар төлөгчид эрсдэлээ өөрөө удирдах боломжтой болсон ба ингэснээр татварын эрсдэлээс өөрийгөө хамгаалах, татварын аливаа зөрчил, дутагдал, алдааг залруулах, татварын хяналт шалгалтад хамрагдахгүй байх боломжууд бий болсон. Үүнтэй холбоотойгоор татварын хяналт шалгалтын процесс цахимжиж, хялбаршуулсан горимд шилжиж байгаа ба хяналт шалгалттай холбоотой цаг хугацаа хэмнэгдэх, хяналт шалгалтын тоо буурах, төрийн удирдлагын зардал буурах зэрэг давуу талууд бий болж байна.
2. Татварын эрсдэлийн үнэлгээ, татварын скорингтой холбоотойгоор татвар төлөгч байгууллагын удирдлага, нягтлан бодогчийн ёс зүй, мэргэжлийн үнэ цэн, хариуцлага дээшилж байна. Өөрөөр хэлбэл, нягтлан бодогч нарын чадамжийг системтэй уялдуулан үнэлэх боломж бүрдсэн буюу А үнэлгээтэй татвар төлөгчийн нягтлан бодогчийн мэргэжлийн ур чадвар, мэдлэг, хандлага сайн гэж дүгнэгдэж байна.
3. Байгууллагын удирдлага санхүүгийн мэдлэгтэй эсэхээс үл хамааран байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодогчдынхоо ажлыг хянах механизм татварын цахим технологиор бий болсон.
4. Ажил олгогчид сайн нягтлан бодогчоор хүний нөөцөө бүрдүүлэх боломж бүрдсэн ба байгууллага бизнесийн болон татварын орчноо сайжруулах боломжууд нэмэгдэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- УИХ (2019) *Татварын Ерөнхий Хууль*. Улаанбаатар хот
- [Сангийн Яам (2019) *Татварын албаны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журам*. Улаанбаатар хот
- Алтанзаяа. Г (2022) *Татварын нягтлан бодох бүртгэл*. Улаанбаатар хот
- Алтанзаяа. Г (2018) *Татвар*. Улаанбаатар хот
- ММНБИ (2021) *Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт*. Улаанбаатар хот
- https://www.pwc.com/mn/en/tax_alerts/pdf/tax_alert_mn_02_2023.pdf
- https://forum.mn/uploads/site/1126/res_mat/2020/ChuhalsedevTax%20LawDiscussion.pdf
- [<https://business.mn/2023/09/11/tatvariin-albanaas-nevtruulsen-tatvariin-skoring-gej-yuu-ve/>
- <https://nta.mn/p/inspection>
- <https://mta.gov.mn/files/pdf/oxxyzrah1ra//6447788ece968129f23214e7.pdf>
- <https://www.zms.mn/a/94355>
- [<http://mongoltax.mn/post/65128>